

**МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭР ДЭХ ЭДЭЛБЭР ГАЗАР БОЛОН ТЭДГЭЭРТ  
БАЙРЛАХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ОБЪЕКТУУДЫН ЭРХИЙГ ОРОСЫН  
ХОЛБООНЫ УЛСЫН НЭР ДЭЭР ШИНЭЧЛЭН БҮРТГЭХ НӨХЦӨЛИЙН ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 06 дугаар  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 75 дугаар зүйлийг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 04 дүгээр сарын 29, 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа тус тус хэлэлцлээ.

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр нь Улаанбаатар, Чойбалсан, Эрдэнэт хотуудад байрлах 8 газар, 93 үл хөдлөх хөрөнгийн объектыг ЗСБНХУ-ын нэр дээрээс ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгүүлэх шаардлагатай гэж үзсэн байна. ОХУ-ын өмчийн үл хөдлөх хөрөнгөд хамаарах газрыг үнэ төлбөргүй, хугацаагүй олгосон байсныг өөрчилж, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу газар ашиглах эрхийг 99 жилийн хугацаатай олгож, зохих татварыг төлөхөөр тусгаж, хавсралт жагсаалтаар нийт 8 нэгж талбарын 9.57 га газрыг ашиглуулах, 93 нэгж үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг баталгаажуулахаар тусгасан байна.

Байнгын хорооны 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар хаалттай хуралдах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж хаалттай хэлэлцсэн бөгөөд уг төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, тодорхой мэдээлэл хангалтгүй байгаа учир холбогдох байгууллагаас нэмэлт мэдээлэл авч танилцах шаардлагатай гэснээр уг асуудлыг түр хойшлуулсан болно.

2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар эдэлбэр газрыг цаашид ашиглах нөхцөлийг 99 жил гэснийг анх ашигласнаас хойш тооцохгүйгээр яагаад шилжүүлсэн өдрөөс тооцож байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр Монгол Улс гадаадад хэчнээн тооны хөрөнгө эзэмшиж, ямар хэмжээний газар ашиглаж байгаа болон энэ талаарх гэрээ, хэлэлцээр, харилцан ашигтай, харилцан тэнцвэртэй байх талаар, өмнө нь Монгол Улсад үнэ төлбөргүй шилжүүлсэн, буцаан олгосон хөрөнгийн мэдээллийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга хэлэлцээрийн төслийн 9 дүгээр зүйлийн талаар, газрыг 99 жилийн хугацаанд ашиглуулах нөхцөлийг Газрын тухай хуулиа баримтлан 15-аас 60 жил

хүртэл гэж өөрчлөх боломжтой эсэх, гуравдагч этгээдэд газрыг шилжүүлбэл хэрхэн зохицуулах талаар, Дархан-Уул аймагт байрлах 7 дугаар байрны асуудал цаашид хэлэлцээрээр шийдэгдэх эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Төрийн өмчийн хороо, Гадаад харилцааны яам гишүүдийн хэлсэн саналууд болон хэлэлцээрийн төслийн гэрээ шинэчлэх хугацаа, зохицуулалттай холбоотой асуудлуудыг анхаарч ажиллах талаар үг хэлсэн болно.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгов.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Г.ТЭМҮҮЛЭН**